

06 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Сумын 100 жилийн ой болохтой холбогдуулан айл өрх, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд гаднах өнгө үзэмжээ сайжруулах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, хаяг гэрэлтүүлэг хийх зэрэг ажлуудыг сумын Засаг даргын удирдамжаар батлуулан бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуй үйлчилгээний цэгүүд болон айл өрхүүдэд шаардлага тавьж үүрэг чиглэл өгч ажилласан. Мөн 2 удаа хяналт, шалгалтаар явсан.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах дэд зөвлөлөөс ирсэн төлөвлөгөөний дагуу сумын цагдаагийн хэсэг ЗДТГ хамтран айл өрхүүдэд хашаандаа бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тэмдэг тэмдэглэгээ гарц гаргалгааг дугуйг будаж байршуулах ажил болон гарын авлага поршур 450 өрхөд тараан сумын цахим группүүдэд мэдээллийг байршуулсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 6 ажлын гүйцэтгэлээр 265053,1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийг нэмэгдүүлэхийн тулд зээлдэгчидтэй утсаар ярих, мэдэгдэл хүргэх, гэр болон ажлын байранд нь биечлэн очиж уулзсан. ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулсан хяналтын зөвлөл газар дээр нь явж шалгалт хийсэн. 6-р сарын байдлаар 4 хүн зээлээ хааж 12665430 төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлээд байна.

Татварын чиглэлээр :

06/14 ны өдөр аймгийн татварын хэлтсийн 4 албан хаагчийн бүрэлдхүүнтэйгээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа 17 аж ахуйн нэгж, 23 бизнес эрхлэгчдийн урьд оны болон тайлант оны өр төлбөр барагдуулалт төлбөрийн баримт олголтонд хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн төлбөрийн баримт олгоогүй ААН, иргэдэд хуулийн хуулийн дагуу хариуцлага ногдуулж зөрчил гаргахгүй ажиллах ажиллах талаар сануулга өгч, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг шалгаж дахин үнэлүүлэх шаардлагатай иргэд, ААН – тэй уулзаж хөрөнгийг ахин үнэлж төлөвлөгөөт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. 06/13-06/18 ны хооронд авто тээврийн үзлэг оношлогоог явагдсан.

Хоер: Нийгмийн бодлогын хүрээнд**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар нийт 41 өрхөөс 1 өрх татгалзаж, 1 өрх эзгүй 39 өрх судалгаанд хамрагдсан. Үүнээс хөдөөний 13 өрх, сумын төвийн 26 өрх орсон.

Уулбаян суманд ажил олгогчийн баруун бүсийн зөвөлгөөн 06/27 нд зохион байгуулагдсан. Малын гаралтай түүхий эдээр өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 1 иргэн шилдэг үйлдвэрлэгчээр шагнал хүртсэн. Дарьганга өв соёлын үзэсгэлэнд оролцох эрхээр 1 өрхийн үйлдвэрлэгч шагнуулсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

6 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд 344 иргэд, сайн дурын даатгалд 496 иргэд хамрагдсан байна. 0-3 хүртэлх насны эхчүүдийн нийгмийн даатгалд 102 эх хамрагдсан. Энэ онд шинээр малчин 6 даатгуулагч хамрагдаад байна.

ЕБС – Бага сургуулийн урсгал засварын ажлыг аймгийн хөрөнгө оруулалт 100,0 сая төгрөг, сумын ОНХС-ын хөрөнгө оруулалт 50,0 сая төгрөг нийт 150,0 сая төгрөгийн санхүүжилтээр СИ-АЙ-ЖИ компани засварын ажлыг хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70 хувьтай хийгдэж байна. 12-р ангийн сурагчид ЭЕШ-нд 7 хичээлээр давхардсан тоогоор 210 сурагч ЭЕШ өгөхөд Монгол хэл-605.3 - Тэргүүн байр / улс, аймгийн дунджаас дээш/ - Математик - 574.3 - Дэд байр /улс, аймгийн дунджаас дээш/ - Англи хэл -528.6- Дэд байр /улс, аймгийн дунджаас дээш/ - Хими - 538.5- IV байр / улс, аймгийн дунджаас дээш/ - Физик- 551.0- IV байр /улс, аймгийн дунджаас дээш/ - Биологи- 526.3- VI байр /улс, аймгийн дунджаас дээш/ - Нийгмийн тухай мэдлэг- 535.4- VI байр / улс, аймгийн дунджаас дээш/ - Түүх-586.0- Гутгаар байр Сургууль нийт дүнгийн дунджаар - 555.1 оноогоор - ДЭД байр эзэлж аймагтаа тэргүүлсэн.

Соёл, урлагын үйлчилгээ:

Сумын 100 жилийн ой болохтой холбогдуулан Соёлын комисс Соёл урлагийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу Хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулах найруулагч, хөгжим, бүжгийн багш нар ирж ажиллаж бэлтгэл ажлыг хангаж байна.

МУ-ын Соёлын яамнаас хэрэгжүүлж Соёлын сэргэлт арга хэмжээг сум орон нутагтаа үр дүнтэй зохион байгуулж тус арга хэмжээнд Соёлын яамны харьяа байгууллагаас 10 уран бүтээлч Аймгийн соёл урлагийн газраас хэлтсийн дарга 1 ахлах мэргэжилтэн 1, сумын удирдлагууд иргэд хүүхэд багачууд оролцлоо. тус арга хэмжээнд нээлт үзэсгэлэн, урлагийн тоглолт, сургалтууд, хөтөлбөрт цэнгүүн зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаж тус арга хэмжээнд давхардсан тоогоор 1400 иргэдийг хамрууллаа.

Сумын 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд засаг даргын нөөцөөс 3.0 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэж байна. Мөн байгууллагын урсгал засварын 3.0 сая төгрөгөөр гадна талбайн тохижилт, цэцгийн мандал, сүүдрэвч зэрэг тохижилтын ажлыг хийж байна.

Соёл урлагийн нэгдсэн 14 арга хэмжээ гадны тоглолт 3 , кино үзвэрийн үйлчилгээ 3, байгууллагаас зохион байгуулсан 6 арга хэмжээнд нийт 2991 үйлчлүүлэгч хамрагдсан байна.

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Номын сангийн фондны хагас жилийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг томилон тооллогыг зохион байгуулан ажиллаа.

Номын сангийн явуулын үйлчилгээг 5 удаа танхимын үйлчилгээг 22 удаа хүргэн танхим болон явуулын үйлчилгээгээр 125 иргэнд 171 номоор үйлчиллээ.

Соёлын сэргэлт арга хэмжээний хүрээнд Шинэ ном, Нутгийн зохиолчдын номын үзэсгэлэнг зохион байгуулан үзэсгэлэнг давхардсан тоогоор 300 гаруй иргэд сонирхлоо.

Соёлын сэргэлт арга хэмжээний үеэр Уртын дууны сургалтанд 31 ардын авьяастан, бүжгийн сургалтанд 70 сурагчид хамрагдан суралцсан байна.

Сумын түүхт 100 жилийн ойд зориулан нутаг орны онцлогийг шингээсэн дараах шинэ уран бүтээлийг шинээр бүтээхээр ажиллаж урлагын хувцас шинээр хийх

Дуурсах алдартай Мөнххаан дууны хөгжмийн найруулга клипжүүлэх

Мөнххааны түүхэн бүжиг, Цээлийн долгио бүжиг шинээр дэглэх

М.Дугаржавын болон Түүх соёлын дурсгалт газар соёлын өвийн чиглэлээр эмхтгэл бэлтгэх, зэрэг уран бүтээлийн ажлууд хийгдэж байна.

-Дээрх шинэ уран бүтээлийн зардалд 30.000.0 төгрөг төсөвлөн хандиваар хийгдэж байна

Эрүүл мэндийн чиглэлээр:

2023 оны 6 сард нийт 28 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 21 насанд хүрэгчид, 7 хүүхэд байна. Түргэн тусламжийн дуудлага 54 ирснээс алсын дуудлага 15, ойрын дуудлага 39 ирсэн. Цаг тухай бүрд нь барагдуулсан. Яаралтай тусламжаар 29 хүн үйлчлүүлсэн. “Наршилт түүнээс сэргийлэх талаар” ЭМТөвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд мэдээлэл хүргэсэн. 50ш тараах материал бэлдэж тараасан. Ахуйн осол гэмтлээс сэргийлэх талаар 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд мэдээлэл сургалт хийж бүртгэл мэдээлэл хөтлөн ажиллаж байна.

МСТНийгэмлэгийн хяналт шалгалтын дагуу амьжиргааны түвшин доогуур болон өрхийн хавьталын судалгааг гаргаж 2020-2023 онд үзлэг шинжилгээнд хамрагдаагүй болон өөр аймаг суманд амьдарч байгаа иргэдийн судалгааг гаргасан.

ОУ-ын Ротари сангийн санхүүжилтээр “Элэгний В,С вирус, элэгний хавдар илрүүлэх” Гепатитгүй монгол төсөл”-ийн хүрээнд манай суманд 2023 оны 06 сарын 26-27 ны өдрүүдэд АНЭ-ийн ЭХО, дотрын эмч нар үзлэг оношилгоо хийж шинжилгээнд 39 хүн хамрагдсанаас В вирус -2 хүн шинээр илэрсэн. С вирусын эм уух шаардлагатай 12 хүн байна. 18-34 насны эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 40 хүн хамрагдсан. В, С вирус илрээгүй.

Гурав: Хөдөө аж ахуйн чиглэлээр : Тооллогын комиссын даргаар батлуулсан төлөвлөгөө, маршрутын дагуу ажиллах тооллогын хэсэг бүрийг тухайн багийн Засаг дарга нар тус тус ахлаж ажилласан. 2023 оны 05 сарын 30-ны өглөө Засаг даргын тамгын газрын гаднаас тус тусын маршрутын дагуу нэгэн зэрэг хөдөлсөн ба 5 багийн 5 машины бензин, жолоочийн хөлс, шивэгчийн хөлс зэрэг статистикийн хэлтэсээс олгогдсон 1406100 төгрөгний зардалыг зориулалтын дагуу

зарцуулсан байна. Сумын хэмжээнд Тооллогын комиссын дарга М.Баасанбат, Санхүү албаны дарга Ш.Жавзандулам нараар ахлуулсан хяналтын 1 хэсэг гарч хуваарийн дагуу хяналт шалгалт хийсэн. Мөн Үндэсний Статистикийн газрын дарга болон Аймгийн статистикийн хэлтэсийн дарга нараар ахлуулсан ажлын хэсэг 5 сарын 30-31-нд хяналтын тоогоор ирж ажиллалаа.

Хяналтын тооллого хийж хотны цайрлага болоод тухайн өдрийн А данстай тулган шалгасан. Хяналтын явцад ямар нэгэн алдаа зөрчил гараагүй.

Дөрөв: Газрын харилцаа, байгаль орчны чиглэлээр:

Хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн олон янз байдлыг хангах төслийн газрын санхүүжилтээр сумын 1-р багийн нутаг Баянцагаан талд 50 толгой тарвага нутагшуулсан. 3-р багийн 1 иргэнээс гомдол ирсний дагуу цагдаагийн хэсэгтэй хамтран 1 удаа хяналт шалгалт хийж хууль бус чулуу түүж байсан иргэдийг тогтоож зөрчлийн хэрэг нээж холбогдох газарт хүргүүлсэн. Энэ хяналт шалгалтанд 204,0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

ОНХС-ын 21,0 сая төгрөгийн төсөвтэй тендэрийн шалгаруулалтанд шалгарсан “ЭКО ЛЭНД МЕНЕЖМЕНТ” ХХК-тай хаягжилтийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулан Гудамж-260, тоот-1440, байшингийн дугаар 40 тус тус тоо хэмжээтэй захиалга өгч одоогоор гүйцэтгэлийн түвшин 90 хувьтай явж байна. 6 сардаа багтаан хаяг хадах тогтоох ажил хийгдэж дуусна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.